

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дугаар зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд “Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН

ХОТЫН СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ****НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хотын стандартыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хотын стандартыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”, “Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль”, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. “Хотын стандарт” гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ тогтоох зорилгоор үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцүүлэн оролцогч талуудын зөвшилцөн боловсруулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан нийслэлийн хэмжээнд мөрдөгдөх хэм хэмжээ тогтоосон баримт бичиг;
- 2.2. “Хотын стандартын бодлогын зөвлөл” /цаашид “Бодлогын зөвлөл” гэх/ гэж нийслэлийн чиг үүрэгтэй холбоотой асуудлаар үндэсний болон хотын стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах чиглэл, цар хүрээг тодорхойлох, хотын стандартыг боловсруулах, техникийн зөвлөлөөр хянан хэлэлцэх, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих, батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх зэрэг цогц арга хэмжээний төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилт, үр дүнг хянан хэлэлцэж зөвлөмж гаргах замаар Нийслэлийн Засаг даргад зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл;
- 2.3. “Хотын стандартын техникийн зөвлөл” /цаашид “Техникийн зөвлөл” гэх/ гэж хотын стандартын төсөл нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт шаардлагад нийцэж, нийслэлийн хөгжлийн бодлого, чиг хандлага, орчин үеийн эрэлт хэрэгцээг хангасан эсэхийг хянан хэлэлцэж санал дүгнэлт гарган Нийслэлийн Засаг даргад зөвлөх чиг үүрэг бүхий холбогдох салбар, мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх зөвлөл;
- 2.4. “Нийслэл хотын стандартчиллын үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний болон хотын стандартын төслийг боловсруулах, иргэд, олон нийт, мэргэжлийн байгууллагуудаас санал авах, хянан хэлэлцэх, батлуулах цогц үйл ажиллагааг зохион байгуулах жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө;

- 2.5. “Хотын стандартын төсөл боловсруулах заавар” гэж хотын стандартын төслийг боловсруулах аргачлал, баримт бичгийн загварыг тодорхойлсон үлгэрчилсэн заавар бөгөөд түүнийг хотын стандарт болгон баталж мөрдөх баримт бичиг.

ГУРАВ. ХОТЫН СТАНДАРТЫН ТОГТОЛЦОО

- 3.1. Хотын стандартын тогтолцоо нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжих хот төлөвлөлт, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон бараа, ажил үйлчилгээний чанарын түвшнийг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхойлох, хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хянах зэрэг харилцан уялдаа бүхий үйл ажиллагааны цогц юм.
- 3.2. Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Хотын стандартын бодлогын зөвлөл”-ийг Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулж дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:
- 3.2.1. “Нийслэл хотын стандартчиллын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-г хэлэлцэн батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;
 - 3.2.2. Хотын стандартын техникийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангаж, хяналт тавих;
 - 3.2.3. Батлагдсан хотын стандартыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтыг хангах.
- 3.3. Хотын стандартын бодлогын зөвлөлд Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагуудаас дараах төлөөллийг оруулна.
- 3.3.1. Нийслэлийн Засаг даргын орлогч /асуудал хариуцсан/
 - 3.3.2. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
 - 3.3.3. Нийслэлийн Ерөнхий архитектор;
 - 3.3.4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга;
 - 3.3.5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга;
 - 3.3.6. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;
 - 3.3.7. Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газрын дарга;
 - 3.3.8. Стандартчилал, хэмжил зүйн газрын төлөөлөл.
- 3.4. Хотын стандартын төслийг хотын хөгжлийн салбар, чиглэл бүрээр дагнан хэлэлцэж дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн зөвлөл (цаашид “Хотын стандартын техникийн зөвлөл” гэх)-ийг “Хотын стандартын бодлогын зөвлөл”-ийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

- 3.4.1. Хотын стандартын төсөл боловсруулах тухай нутгийн захиргааны болон харьяа байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийн саналыг нэгтгэн судлах, “Нийслэл хотын стандартчиллын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах”;
- 3.4.2. Хотын стандартын төслийг хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, үндэсний стандарт, техникийн зохицуулалттай нийцүүлэх талаар судлан хянаж Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар өргөн барих эсэх талаар дүгнэлт гаргах;
- 3.4.3. Хотын стандартын төслийг холбогдох заавар, тавигдах шаардлагад нийцүүлэх талаар төсөл боловсруулагч байгууллага, аж ахуйн нэгжид зөвлөмж өгөх;
- 3.4.4. Хотын стандартын бодлогын зөвлөлийн баталсан төлөвлөгөө, удирдамж зааврын дагуу зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж зохих хугацаанд тайлагнана.

ДӨРӨВ. ХОТЫН СТАНДАРТЫН ТОГТОЛЦООНД ОРОЛЦОГЧДЫН ЧИГ ҮҮРЭГ

- 4.1. Хотын стандартын тогтолцоонд оролцогчдыг дараах байдлаар ангилна.
 - 4.1.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд;
 - 4.1.2. Нийслэлийн өмчит болон харьяа байгууллагууд;
 - 4.1.3. Мэргэжлийн холбоод;
 - 4.1.4. Аж ахуйн нэгж байгууллагууд;
 - 4.1.5. Иргэд, олон нийт;
- 4.2. Нийслэлийн Засаг даргын чиг үүрэг
 - 4.2.1. Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцаж, тайлагнах;
 - 4.2.2. Хотын стандартын төслийг хянан хэлэлцэх мэргэжлийн чиг үүрэг бүхий “Хотын стандартын техникийн зөвлөл”-ийг салбар, мэргэжлийн чиглэл бүрээр байгуулах;
 - 4.2.3. Хотын стандартын техникийн Зөвлөлийн ажиллах нийтлэг дүрмийг батлах;
 - 4.2.4. Хотын стандартын бодлогын зөвлөл, техникийн зөвлөлийн ажлын үр дүнг үнэлж мөнгөн урамшуулал олгох.
- 4.3. Хотын стандартын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг
 - 4.3.1. Хотын стандартын бодлогын зөвлөл, техникийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах;
 - 4.3.2. Хотын стандартын техникийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

- 4.3.3. Хотын стандартын төслийг боловсруулах, хянан хэлэлцэх хотын стандартын техникийн зөвлөлийн бүрэлдэхүүн байгууллагуудыг сургалт, арга зүйгээр хангах;
 - 4.3.4. Хотын стандартыг бүртгэх, мэдээллийн санг эрхлэх, албан ёсны эхийг хадгалах, олон нийтэд мэдээлэх, сурталчлах.
 - 4.3.5. Хотын стандартыг боловсруулахтай холбогдуулан гадаад, дотоодын эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллага, зөвлөлтэй хамтран ажиллах;
 - 4.3.6. “Хотын стандартын төсөл боловсруулах заавар”-ыг боловсруулах;
 - 4.3.7. Хотын стандартад үзлэг хийх ажлыг зохион байгуулах.
- 4.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нийтлэг чиг үүрэг
- 4.4.1. Хотын стандартыг мөрдөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
 - 4.4.2. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хотын стандартын төслийг боловсруулах, санал өгөх;
 - 4.4.3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хотын стандартын хэрэгжилтийг үнэлэх, хотын стандартад үзлэг хийхэд хамтран ажиллах;
 - 4.4.4. Хотын стандартын талаар албан хаагчдын мэдлэг, ойлголтыг төлөвшүүлж сургалтад хамруулах.
- 4.5. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын чиг үүрэг
- 4.5.1. Хотын стандартыг мөрдөх;
 - 4.5.2. Хотын стандартын төслийг санаачлах, төсөлд санал өгөх, хамтран ажиллах;
 - 4.5.3. Хотын стандартын талаарх мэдээллээр хангагдах.

ТАВ. ХОТЫН СТАНДАРТЫН ТОГТОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ

- 5.1. Хотын стандартын тогтолцоо нь дараах үндсэн үйл явцтай.
- 5.1.1. Хотын стандартын төслийг боловсруулж батлуулах;
 - 5.1.2. Хотын стандартыг таниулан сурталчилах;
 - 5.1.3. Хотын стандартыг мөрдүүлэх;
 - 5.1.4. Хотын стандартад үзлэг хийх;
- 5.2. Хотын стандартыг боловсруулж батлуулах үйл явцыг дараах үе шатанд ангилан авч үзнэ. Үүнд:
- 5.2.1. Хотын стандартын төслийг санаачлах, суурь судалгаа хийх;
 - 5.2.2. Хотын стандартын төслийн анхны хувилбарыг боловсруулах;
 - 5.2.3. Хотын стандартын төсөлд санал авах;
 - 5.2.4. Хотын стандартын төслийг техникийн зөвлөлөөр хянан хэлэлцүүлэх;
 - 5.2.5. Хотын стандартыг төслийг хянан тохиолдуулах;

- 5.2.6. Хотын стандартыг батлуулах (Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих, хэлэлцүүлэх);
- 5.3. Хотын стандартыг санаачлах
 - 5.3.1. Хотын стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг нийслэлийн Засаг дарга, нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллага, орон нутгийн өмчит компани, төрийн бус байгууллага, иргэд зэрэг хотын стандартын тогтолцоонд оролцогч аливаа этгээд гаргах эрхтэй.
 - 5.3.2. Хотын стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг холбогдох үнэн бодит судалгааны үр дүнгээр тодорхойлсон байна.
- 5.4. Хотын стандарт боловсруулах
 - 5.4.1. Хотын стандартын төслийг боловсруулахдаа холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, үндэсний стандартад нийцүүлэн “Хотын стандартын төсөл боловсруулах заавар”-ын дагуу боловсруулна.
 - 5.4.2. Хотын стандарт нь нийгэм, эдийн засгийн хөгжил, инноваци, шинжлэх ухаан, технологийн судалгаанд тулгуурласан байна.
 - 5.4.3. Хотын стандартын төслийг боловсруулахад холбогдох мэргэжлийн байгууллага, олон нийт, иргэдийн саналыг авч тусгана.
 - 5.4.4. Хотын стандартын хамрах хүрээ, салбар мэргэжлийн онцлогоос хамааран, Хотын стандартын төслийг Хотын стандартын техникийн зөвлөл хянан хэлэлцэнэ.
 - 5.4.5. Хотын стандартыг боловсруулахад шинжлэх ухаан, технологийн туршилт, судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай бол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн дагуу холбогдох мэргэжлийн чиглэлээр өндөр мэдлэг, туршлагатай зөвлөх үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.
- 5.5. Хотын стандартын техникийн зөвлөл нь сонирхогч талуудын оролцоог тэгш хангаж тухайн салбар чиглэлээр мэргэшсэн, судалгааны арга зүйг эзэмшсэн гишүүдээс бүрдэх бөгөөд нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй байна.
- 5.6. Техникийн зөвлөлийн үйл ажиллагааг “Хотын стандартын техникийн зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулна.
- 5.7. Хотын стандартыг батлуулах
 - 5.7.1. Хотын стандартын бодлогын зөвлөлийн шийдвэр, зөвлөмжийг үндэслэн Хотын стандарт, түүний нэмэлт өөрчлөлтийн төслийг Нийслэлийн Засаг даргын зүгээс Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулна.
 - 5.7.2. Батлагдсан хотын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

5.8. Хотын стандартыг сурталчилан таниулах

- 5.8.1. Хотын стандартын мэдээллийн нэгдсэн санг үүсгэж иргэд, олон нийтэд ил тод нээлттэй түгээн сурталчилна.
- 5.8.2. Хотын стандартыг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад сурталчилан таниулах арга хэмжээг тухайн асуудал хариуцсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллага гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган зохион байгуулна.
- 5.8.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид өөрийн ажиллаж буй салбар, чиглэлд хамаарах хотын стандартын талаар бүрэн мэдлэг, ойлголттой байх тухай албан тушаалын тусгай шаардлагыг хангуулна.

5.9. Хотын стандартыг мөрдүүлэх

- 5.9.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх аливаа бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд хотын стандартыг мөрдөнө.
- 5.9.2. Хотын стандартыг мөрдүүлэх үйл явц нь бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дараах үе шатуудад мөрдөнө. Үүнд:

- 5.9.2.1. Төлөвлөх;
- 5.9.2.2. Бараа, ажил үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох;
- 5.9.2.3. Зураг төсөл боловсруулах, төсөв, зардлыг тооцох;
- 5.9.2.4. Ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх;
- 5.9.2.5. Хүлээн авах;
- 5.9.2.6. Ашиглалт, засвар үйлчилгээ хийх;

5.10. Хотын стандартад 2 жил тутамд үзлэг хийж шинэчлэн сайжруулах шаардлагатай эсэх талаар нэгдсэн дүгнэлтийг Хотын стандартын бодлогын зөвлөлөөс гаргана.

5.11. Хотын стандартын хэрэгжилтийн хяналт

- 5.11.1. Хотын стандартын хэрэгжилтийн хяналтыг Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулагдана.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.